



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 04 өдөр

Дугаар A/25

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагааэрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5. дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цэгц шагай ХХК-ийн “Мираж” зочид буудлын 13/248, Бумбашүр ХХК-ийн “Лайк” зочид буудлын 16/119, Шанш ХХК-ийн “Хантерс” дэн буудлын 16/051, Вайт анжел ХХК-ийн “Анжел” дэн буудлын 17/031, ЦЖК трейд ХХК-ийн “Эндо” дэн буудлын 17/004, Төгс сайн ХХК-ийн “Төгс сайн” дэн буудлын 13/113, Эйч эл кэй эм эн ХХК-ийн “Вегвайсер” дэн буудлын 17/036, Эбоги ХХК-ийн “Уулзвар 21” дэн буудлын 15/016, Жингийн халзан ХХК-ийн “Харз 2” дэн буудлын 17/062, Юу би эс ар ХХК-ийн “Мини буудал” дэн буудлын 17/033, гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.



ДАРГА

Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын дартын 2018 оны 04 сарын 04
өдрийн №5 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.04.04

Улаанбаатар хот

Д/ д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Цэгц шагай ХХК	5126231	Мираж	СХД-ийн 19-р хороо ҮЭ- 55 тоот
2	Бумбашүр ХХК	5332664	Лайк	БЗД-ийн 6-р хороо 13-р хороолол 226-148

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын дарын 2018 оны 04. сарын 04
өдрийн 125 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

11113265
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХҮЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.04.04

Улаанбаатар хот

Д/ д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Шанш ХХК	2020351	Хантерс	БЗД-ийн 4-р хороо Б.Доржийн гудамж 486
2	Вайт анжел ХХК	5573343	Анжел	ЧД-ийн 2-р хороо Чойбалын гудамж
3	ЦЖ трейд ХХК	2622998	Эндо	БГД-ийн 16-р хороо Орхоны 4-р гудамж 19
4	Төгс сайн ХХК	5011817	Төгс сайн	БГД-ийн 8-р хороо Жамсранжавын гудамж 5
5	Эйч эл кэй эм эн ХХК	5883474	Вегвайсер	СХД-ийн 15-р хороо Өнөр хороолол 51
6	Эбоги ХХК	2047039	Уулзвар 21	СХД-ийн 27-р хороо Тоосгоны 33-р байр
7	Жингийн халзан ХХК	2724464	Харз 2	СХД-ийн 10-р хороо зүүн баян уул 7-3
8	Юу би эс ар ХХК	5327512	Мини буудал	БГД-ийн 5-р хороо 45-р байр
9	Уулс болд ХХК	2674548	Болор 1	БЗД-ийн 18-р хороо 13-р хороолол 1-1
10	Аз тулга ХХК	5117518	Дэлгэрэх	БГД-ийн 23-р хороо зүүн ард Аюуш 25-7, 119
11	Касио ХХК	2664402	Ану	СХД-ийн 27-р хороо Толгойт 22 тоот
12	Хийморийн нөмөр ХХК	5494052	Эд	БЗД-ийн 2-р хороо АОС гудамж 46 тоот
13	Бумбатхайрхан нутаг ХХК	2701855	Даймонд	БЗД-ийн 1-р хороо Ус сувгийн 30
14	Эцэг эх ХХК	2574896	Номуун	ЧД-ийн 6-р хороолол 48-р байр

--ооОоо--